

БАТЛАВ
"ДБЭХС" ТӨХК-ийн СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
САЛБАРЫН ДАРГА П.НАРАНТУЯА

"ДБЭХС" ТӨХК-ийн СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ САЛБАР

**БАРИЛГА, САНТЕХНИКИЙН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалт/
гэрээний нэр:

Барилга, сантехникийн материал нийлүүлэх
нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалт

Тендер
шалгаруулалт/
гэрээний дугаар:

ДБЭХС/202001102

Хянасан: Үнэлгээний хорооны дарга:

Гишүүд:

С.Батхүү

Н.Соронзонболд

Ч.Энхчулуун

Б.Галсанжамц

Боловсруулсан: Нарийн бичгийн дарга:

А.Түмэнбаяр

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.03.05

[“ДБЭХС” ТӨХК-ийн Сүхбаатар аймаг дахь салбар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Барилга, сантехникийн материал нийлүүлэх]** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 03 дүгээрсарын 12-ны өдөр 10 цаг 00 минут]-**аас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/ хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 03 дүгээр сарын 12]-**ны өдрийн **[10 цаг 30 минут]** -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Цахим худалдан авах систем (www.tender.gov.mn)

[Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 1-р баг, “ДБЭХС” ТӨХК-ийн Сүхбаатар аймаг дахь салбарын байрны 1 давхар 103 тоот өрөө утас 99512332, 91113964]

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл / болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**


6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Санхүүгийн болон техникийн дараах шаардлагуудыг хангасан байх ба холбогдох материалыг ирүүлнэ. Үүнд:</p> <p>1. Сүүлийн 1 жилийн буюу 2018 оны санхүүгийн тайлан.</p> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ol style="list-style-type: none">1. Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар2. Харьяа банкны тодорхойлолт / тулгамдсан өргүй байх/3. Татварын газрын тодорхойлолт /татварын өргүй байх /4. Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байх5. Харьяалагдах нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /сүүлийн 1 жилийн хугацаанд/6. Шүүхийн байгууллагын тодорхойлолт7. Жилийн борлуулалтын орлого 20 сая-с доошгүй байх <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Шаардлагагүй</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээж авах эцсийн хугацаа:</p> <p>Байгууллагын хаяг: Сүхбаатар аймаг Баруун-Урт сум 1-р баг "ДБЭХС" ТӨХК-ийн Сүхбаатар аймаг дахь салбарын байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1-р давхар 103 тоот</p> <p>Огноо: 2020 оны 03-р сарын 12-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Сүхбаатар аймаг Баруун-Урт сум 1-р баг "ДБЭХС" ТӨХК-ийн Сүхбаатар аймаг дахь салбарын байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1-р давхар 103 тоот</p> <p>Огноо: 2020 оны 03-р сарын 12-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ. /Байхгүй/</p>

Дөрөв.ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



БАРИЛГА, САНТЕХНИКИЙН МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Баруун-Урт

2020.02.14

№	Материалын нэр	Марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	Өнөрүүш	дунд	ш	86	Стандарт, чанарын шаардлагад нийцсэн барилгын өргөн хэрэглээний материал буюу эсвэл түүнтэй дүйцэхүйц
2	Өнөрүүш	том	ш	52	
3	Багс	жижиг	ш	182	
4	Багс	том	ш	60	
5	Будаг	Бүх өнгө	л	806	
6	Будаг шингэлэгч	500г	л	85	
7	Цемент	50кг	уут	20	
8	Гадна эмульс	салонгос	л	90	
9	Бүргэд хаалга	200*95	ш	1	
10	Разетка	ил16-25А	ш	3	
11	Унтраалга	ил	ш	3	
12	Госжуурын крант		ш	3	
13	Госжуурын хаалт		ш	3	
14	Госжуурын холбоо	1м	ш	6	
15	Уян хоолой	1м	ш	6	
16	Нойлын усны татуурга		ш	4	
17	Нойлын суултуурын таг		ш	2	
18	ПВС хоолой	50мм	м	650	
19	Цасны шүүр	ногоон	ш	4	
20	Хогийн шүүр		ш	2	
21	Цоож	зүүдэг	ш	12	
22	Цоож	зүүдэг	ш	250	
23	Банз	Ф 2.5	ш	100	
24	Банз	Ф 5	ш	10	
25	Палк	Ф 15	ш	6	
26	Пигмент	Өнгө	ш	15	
27	Цавуу	шар	ш	20	
28	Хулдаас	зузаан	м	20	
29	Электрод	Ф 0.2мм	кг	95	
30	Зүсэлгчийн ир	жижиг	Хайрцаг	22	
31	Төмрийн шрул	4.2*20мм	Хайрцаг	6	
32	Төмөр утас	жианда	боодол	3	
33	Шрул	хөр 5см	Хайрцаг	5	
34	Нугас	Том	хос	10	
35	Нугас	жижиг	хос	60	
36	Хадагчны хадаас	Ф 5*18	хайрцаг	8	
37	Хадаас	10см	кг	2	

38	Гадна лед гэрэл	150Вт	ш	12
39	Гадна лед гэрэл	жониг	ш	8
40	Лампа	HIPPO	ш	16
41	Хасах гэрэл	HIPPO	ком	10
42	Цүү /хос/	ТОМ	ш	120

АХЛАХ ИНЖЕНЕР
ХЯНАСАН: 
БОЛОВСРУУЛСАН:
ТУ-НИЙ ИНЖЕНЕР 
С.САЙНЗАЯА
А.ТҮМЭНБАЯР

1. **Стандарт:** Нийлүүлэх материал нь Олон улсын стандартын шаардлага хангасан байна.
2. **Баглаа боодол:** Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Мөн ачааны дагалдах баримт бичгийг хавсарган захиалагчийн хүлээн авах газарт хуваарийн дагуу ирүүлнэ.
3. **Бараа хүргэх газар:** Сүхбаатар аймаг Баруун-Урт сум "ДБЭХС" ТӨХК-ийн Сүхбаатар аймаг дахь салбарын байр
4. **Бараа материалын нийлүүлэлтийн хуваарь:** Гэрээ байгуулагдсанаас хойш 2020 оны 12-р сарын 31-ны өдөр хүртэл хугацаанд захиалагчийн өгсөн жагсаалтын дагуу бэлтгэн нийлүүлэх.

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Д/д	Материалын нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	Өнхрүүш	ш	86	Сүхбаатар аймаг Баруун-Урт сум “ДБЭХС” ТӨХК-ийн Сүхбаатар аймаг дахь салбар	Гэрээ байгуулагд санаас хойш 5 хоногийн дотор	2020.12.31	
2	Өнхрүүш	ш	52			2020.12.31	
3	Багс	ш	182			2020.12.31	
4	Багс	ш	60			2020.12.31	
5	Будаг	л	806			2020.12.31	
6	Будаг шингэлэгч	л	85			2020.12.31	
7	Цемент	уут	20			2020.12.31	
8	Гадна эмульс	л	90			2020.12.31	
9	Бүргэд хаалга	ш	1			2020.12.31	
10	Разетка	ш	3			2020.12.31	
11	Унтраалга	ш	3			2020.12.31	
12	Гоожуурын крант	ш	3			2020.12.31	
13	Гоожуурын хаалт	ш	3			2020.12.31	
14	Гоожуурын холбоо	ш	6			2020.12.31	
15	Уян хоолой	ш	6			2020.12.31	
16	Нойлын усны татуурга	ш	4			2020.12.31	
17	Нойлын суултуурын таг	ш	2			2020.12.31	
18	ПВС хоолой	м	650			2020.12.31	
19	Цасны шүүр	ш	4			2020.12.31	
20	Хогийн шүүр	ш	2			2020.12.31	
21	Цоож	ш	12			2020.12.31	
22	Цоож	ш	250			2020.12.31	
23	Банз	ш	100			2020.12.31	
24	Банз	ш	10			2020.12.31	
25	Палк	ш	6			2020.12.31	
26	Пигмент	ш	15			2020.12.31	
27	Цавуу	ш	20			2020.12.31	

28	Хулдаас	м	20		2020.12.31	
29	Электрод	кг	95		2020.12.31	
30	Зүсэгчний ир	хайрцаг	22		2020.12.31	
31	Төмрийн шруп	хайрцаг	6		2020.12.31	
32	Төмөр утас	боодол	3		2020.12.31	
33	Шруп	хайрцаг	5		2020.12.31	
34	Нугас	хос	10		2020.12.31	
35	Нугас	хос	60		2020.12.31	
36	Хадагчны хадаас	хайрцаг	8		2020.12.31	
37	Хадаас	кг	2		2020.12.31	
38	Гадна лед гэрэл	ш	12		2020.12.31	
39	Гадна лед гэрэл	ш	8		2020.12.31	
40	Лампа	ш	16		2020.12.31	
41	Хасах гэрэл	КОМ	10		2020.12.31	
42	Цүү /хос/	ш	120		2020.12.31	

Тав . **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойл олт	Бараан ы гарал үүслийн улс	Тоо ширхэ г	Нэг ж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа . ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана |

Долоо . ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Барааг захиалагчид хүлээлгэж өгөхдөө шалгаж туршиж хүлээлгэн өгнө.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[100]** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)**
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,05]**
- Алдангийн нийт дүн: **[100,000]**

Найм . ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ___ дугаар сарын ___-наас _____ оны ___ дугаар сарын ___-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]